



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 5/12

Ховд

Б.Хатанзоригийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 05/870 тоот албан бичгээр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирсэн Батхүүгийн Хатанзоригийг “Шинэ Ховд үйлдвэр технологийн парк” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргын албан тушаалд 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Хатанзоригийг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-ний 9 дүгээр хавсралтын дагуу ТҮ11-1 дэх шатлал болох 905714 төгрөг /Есөн зуун таван мянга долоон зуун арван дөрвөн/-өөр цалинжуулсугай.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Хатанзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ